



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 132

Номгон

Үндсэн хөрөнгө акталж
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Галуут сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 нэр төрлийн 25 434 691 /Хорин таван сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун ерэн нэгэн/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг акталж данснаас хассугай.

2. Галуут сумын Засаг дарга /С.Баярсайхан/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

2.1. Тус сумын Засаг даргын Тамгын газрын актлагдсан хогийн автомашиныг Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх;

2.2. Актлагдсан тээврийн хэрэгслийг сэлбэгээр худалдан борлуулж орлогыг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

3.1. Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


3.2. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2020 оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190229



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны
өдрийн 132 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, сумдын нэр	Байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглалта-д орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөл	Тайлбар
1	Галуут сум	Засаг даргын Тамгын газар	1-р баг мотор	2016.01.01	1	529 691	529 691,00	529 691	-	Эвдэрсэн. Засвар авах боломжгүй. Актлах
2	Галуут сум	Засаг даргын Тамгын газар	Трактор	2009.01.01	1	1 405 000	1 405 000,00	1 405 000	-	Акталж сэлбэгээр худалдан борлуулан орлогыг ОНӨГ-ын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх
3	Галуут сум	Засаг даргын Тамгын газар	Зил 130 сонсмол	2011.12.31	1	3 500 000	3 500 000,00	3 500 000	-	Акталж сэлбэгээр худалдан борлуулан орлогыг ОНӨГ-ын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх
4	Галуут сум	Засаг даргын Тамгын газар	Хогны машин	2013.08.07	1	20 000 000	20 000 000,00	20 000 000	-	Акталж Баянбулаг сумын ЗДТГ-т сэлбэгээр ашиглуулах
АКТЛАХ ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН						4	25 434 691	25 434 691		

000